



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/202

Өмнөдэлгэр сум

**Газар эзэмших эрхийн гэрчилгээний
зориулалт өөрчлөх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66 дугаар зүйлийн 66.3, "Газрын тухай" хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдолыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.дэх заалт, Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журмын 7-р заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу газрын эрхийн гэрчилгээний зориулалт өөрчлөх тухай нотлох баримтыг бүрдүүлэн өргөдөл гаргасан Сосорбарамын Энхтүвшингийн холбогдох бичиг баримтыг үндэслэн газар эзэмших эрхийн гэрчилгээг хавсралтад дурдсанаар 1 иргэн 1 нэгж талбарыг өөрчилсүгэй.

2. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж хуулийн дагуу газрын зориулалтыг өөрчилж, газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон, гэрээ байгуулахыг Газрын даамал (Ё.Мөнх-Өлзий)-д зөвшөөрсүгэй.

3. Газрыг зориулалтын дагуу ашиглаж газрын төлбөрийг гэрээнд заасан хугацаанд тогтмол төлж, жил бүр гэрээгээ дүгнүүлж байхыг газар эзэмшигч иргэдэд даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2026 оны 05 дугаар сарын 04-ний А/141 дүгээр захирамжийн (Сосорбарамын Энхтүвшин)-д холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.



Р.ЭНХТӨР

D:\disk\bichig hereg/ zahiramj/

2326310406